"ТЕРМЕС ЦЕНТР" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

оны 3-р сарын 20-ны өдөр Улаанбаатар хот

2020 оны 03-р сарын 20-ны өдөр компанийн өөрийн байрны 3 давхарт байрлах хурлын 15.00 цагаас цахим хэлбэрээр, онлайн орчинд болж өнгөрлөө. Хурлын ирцийн бүртгэлийг эзэмшигчдийн хурлын тооллогын комисс явууллаа. Хурлыг хурал зохион байгуулах ын дарга О.Энхтуяа нээж үг хэлэв.

зохион байгуулах комиссын дарга О.Энхтуяа: Сайн байна уу. Энэ удаагийн хувьцаа чдийн ээлжит хуралд онлайн хэлбэрийг ашиглан оролцож байгаа хувьцаа эзэмшигчид та баярлалаа. Намайг О.Энхтуяа гэдэг, энэ компанид нягтлан бодогчоор ажилладаг. Удирдах Зөвлөлийн шийдвэрийн дагуу өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссын даргаар томилогдон ажиллаж байна. Ингээд та бүхэнд дэг, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулья.

энэ хурлаар дараах 6 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

1. Компанийн 2019 оны бизнесийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлт
2. Компанийн 2019 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланд хийсэн компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт
3. Компанийн 2018 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2019 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2020 оны ногдол ашгийн тухай
4. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, зардлын төсвийн тухай
5. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай
6. Компанийн 2020 оны үйл ажиллагааны зорилт тухай

дэгийн дагуу хурлын тэргүүлэгчийг сонгосон тухай мэдээллийг та бүхэнд хүргэж байна. Компанийн дүрмийн 7.5-р заалтын дагуу "ХЭХурлын дарга"-аар Төлөөлөн Удирдах ийн дарга байна гэсэн заалтыг үндэслэн хурлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга үнөүрэн удирдан явуулна.

Компанийн тухай хууль болон холбогдох журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит ирцийг бүртгэж байгаа тооллогын комиссоос хурлын ирцийн талаарх мэдээллийг бидэнд ж байна. Хурлын ирц 15.00 цагийн байдлаар 85.74 хувьтай байна. Нийт 961 хувьцаа чдээс 9 хувьцаа эзэмшигчид ээлжит хуралд онлайнаар оролцож байна. Брокер диллерийн нудаас саналын хуудас ирсэнгүй. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, тооллогын тгоолыг үндэслэн хурлын ирцийг хангалттай гэж үзээд, хурал нээснийг мэдэгдэж

эзэмшигчдийн хурлын дарга Д.Оюунсүрэн ээлжит хурлыг нээв.

дарга Д.Оюунсүрэн: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц хангалттай тул хуралдаа Дэлхий нийтийг хамарч байгаа халдварт өвчин болох COVID-19 коронавирус манай улс мань илэрсэн байгаа тул Улсын Онцгой комиссын даргын 2020 оны 4 тоот тушаал болон оны огсөн зөвлөмжийг үндэслэн 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл онлайн хэлбэрээр явуулж байна. Хуралдаа оролцож байгаа та бүхэндээ баярлалаа. чууд бидний хувьд энэ халдварт өвчнийг хамтдаа ялан дийлж, компанийнхаа бизнесийн

үйл ажиллагааг тогтвортой авч үлдэх нь бидний нэн тэргүүний зорилт болж байна. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт болон хурлын дэгийг та бүхэнд брокер компаниудаар дамжигдан онлайнаар хүргэгдсэн хурлын материалд байгаа тул хурлаа хэлбэрээр явуулах саналтай байна. Мөн түүнчлэн хэлэлцэж байгаа асуудал бүр дээр эзэмшигчид та бүхэн саналаа илэрхийлэх бүрэн эрхтэй. Хувьцаа эзэмшигчид та бүхэн онцгой нөхцөл байдлыг ойлгон хүлээн авч байгаа бол, мөн онц гойд санал байхгүй болон материалтай урьдчилан сайтар танилцсан бол санал хураалтыг саналын хуудас дээр хийгээд явах бүрэн боломжтой гэж үзэж байна. Саналын хуудсыг компанийн тооллогын гишүүд та бүхний байгаа газарт хүрэлцэн очиж, гарын үсэг зуруулан хүлээн авна.

1. ***Хэлэлцсэн асуудал: Компанийн 2019 оны бизнесийн болон үйл ажиллагааны ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийн тухай. Хэлэлцүүлэгч Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг***

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: Сайн байцгаана уу эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид компанийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хуралдаа онлайнаар оролцож, эзэмшигчийнхээ үүргийг биелүүлж байгаад компанийн гүйцэтгэх удирдлагын омнөх хувиасаа талархал илэрхийлье.

"Ая тухыг эрхэмлэгч" уриатай манай "Гермес центр" хувьцаат компани нь өнгөрсөн барилгын материалын худалдааны төвийн үйл ажиллагааг явуулахдаа

Нэгдүгээрт : Худалдан авагчдын эрх ашгийг дээдэлж, ая тухтай үйлчилж
Хоёрдугаарт : Түрээслэгчдийн эрх ашгийг дээдэлж, тэднийг ажиллах нөхцлөөр хөнгөлөн
Гуравдугаарт : Ажиллагсдынхаа эрх ашгийг хамгаалж, нийгмийн асуудлыг шийдэх
Дөрөвдүгээрт : Хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцааны өгөөжийг нэмэгдүүлж ажиллах

Компани 2019 онд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөв, орлого зарлагын төлөвлөгөөний дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд :

- Худалдааны төвийн захиргаа нь давхардсан тоогоор 200 гаруй түрээслэгч аж ахуйн иргэдтэй түрээсийн гэрээ байгуулан ажилласан. Худалдааны төвийн түрээслэгчдэд даатгалд бүрэн хамруулсан. Түрээслэгчдэдээ сар бүр тогтмол албан захидал хүргэн харилцан ойлголцож, хамтран ажиллаж ирлээ.
- Түрээслэгчдийн дунд арилжааны банк, даатгалын компани, татварын байгууллага байдлын хэлтэстэй хамтран уулзалт өдөрлөг, сургалт семинарыг зохион явуулж ажилласан. Үүнд : ХХБанк, ХААН банк, Голомт банк, Капитрон банк, Монгол даатгал компани даатгал, Соёмбо даатгал гэх зэрэг болно. Мөн арилжааны банкууд манай худалдаа төвийн түрээслэгчдэд 20-с 30 сая төгрөг хүртэлх бизнесийн зээлийг барьцаагүй болсон. Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран гамшгийн үеэ мэдээллийн дохиогоор ажиллах болон галын аюулгүй байдлын сургалт дадлагаа түрээслэгч, ажиллагсдын дунд зохион байгуулсан. Баянгол дүүргийн 4-р хорооны цагдаагийн албатай хамтран хулгай, залилан, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх сургалт зөвлөмжийг түрээслэгчдэд өгч ажиллалаа.
- Худалдааны төвийн өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд хийгддэг жижиг болон засвар, цэвэрлэгээ үйлчилгээний ажлуудыг тогтмол хийж гүйцэтгэсэн
- Батлагдсан хөрөнгө оруулалтын төсвийн хүрээнд худалдааны төвийн "А" корпусын давхруудад 4 ширхэг, гадна талбайд 2 ширхэг хяналтын камер, 1 ширхэг хяналтын 1 ширхэг камерын бичигчийг шинээр суурилуулж, мөн оффисын 3 ажилтны компани ширхэг хурлын сандал зэргийг шинэчилж худалдан авахад нийт 10.5 сая төгрөг зарлаг

Худалдааны төвийн мэдээллийн самбарын мэдээ, мэдээллийг сар бүр тогтмол шинэчилж, хууль эрх зүйн болон бусад ач холбогдолтой мэдээллээр худалдан авагч, түрээслэгч, ажиллагсдыг хангаж ажилласан.

Компанийн бүтэн жилийн тайланд аудитын "Цэсб аудит" ХХК-иар хяналт шалгалтын ажлыг хийлгэж, дүгнэлтийг гаргуулсан.

Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль, эрх зүйн заавар журмын дагуу компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг МХБирж, Санхүүгийн зохицуулах хороонд цаг хугацаанд нь хүргүүлж, МХБирж болон өөрийн компанийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлж ирлээ.

Компанийн санхүүгийн үндсэн үзүүлэлтийн тухай : Компанийн нийт хөрөнгө 8 401.6 сая төгрөг бөгөөд үүнээс :

- Эргэлтийн хөрөнгө 1 874.2 сая төгрөг
- Үндсэн хөрөнгө 4 238.9 сая төгрөг
- Биет бус хөрөнгө 2 288.5 сая төгрөг
- Эзэмшигчийн өмч хөрөнгө 7 854.3 сая төгрөг
- Татварын дараах цэвэр ашиг 820.0 сая төгрөг байна.

Татвар төлөлтийн тухай :Компани 2019 онд татварын байгууллагад нийтдээ 435.3 сая төгрөгийн татварыг төлсөн. Үүнд:

- ААН-ийн ОАТатварт 89.8 сая төгрөг
- НДШимтгэлд сая төгрөг 62.2
- Ажиллагсдын цалингаас суутгасан хувь хүний ОАТатварт 21.0 сая төгрөг
- НӨАТатварт 127.7 сая төгрөг
- ҮХЭХАТатварт 48.2 сая төгрөг
- Ногдол ашгийн татварт 74.6 сая төгрөг
- Газрын төлбөрт 11.8 сая төгрөг

Орлогын үр дүнгийн тухай : Компани 2019 онд нийтдээ 1 652.5 сая төгрөгийн орлоготой ажилласан. Жилийн эцсийн дүнгээр орлогын нийт дүн төсөвлөсөн 1 606.5 сая төгрөгийн орлогын дүнтэй харьцуулахад 103.0%-ийн биелэлттэй байна.

Зардлын тухай : Компани 2019 онд 740.8 сая төгрөгийн зардал гаргасан болно. Зардлын төлөвлөгөө 772.4 сая төгрөг байсантай харьцуулахад төлөвлөгөөний биелэлт 95%-ийн биелэлттэй гарсан. Компанийн хэмжээгээр зардлыг төсөвлөснөөс 31.6 сая төгрөгөөр хэмнэж ажилласан.

Ашгийн тухай : Компани 2019 оны эцэст 820.0 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан. Ашгийн төлөвлөгөө 750.7 сая төгрөг байсантай харьцуулахад ашгийн төлөвлөгөөг 109%-иар буюу 69.3 сая төгрөгөөр давуулан биелүүлж ажилласан.

Компани нь нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн төлөвлөгөөг дараах байдлаар биелүүлсэн. Үүнд : 2019 оны нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн төлөвлөгөө 9 төгрөг 56 мөнгө байсан бол санхүүгийн тайлангаар нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 10 төгрөг 44 мөнгө болж, төлөвлөгөөг 9%-иар давуулан ажилласан.

компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь гүйцэтгэх удирдлагын багийн 2019 онд хийж үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сайшааж тэмдэглэсэн.

2015 - 2019 он хүртэлх сүүлийн 5 жилийн эдийн засгийн ерөнхий судалгааг шинэчлэн хувьцаа эзэмшигч та бүхэнд танилцуулж байна.

Санхүүгийн үзүүлэлт /төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он	2018 он
1	Эргэлтийн хөрөнгө	1,403,086,689.58	1,541,179,226.10	1,678,326,249.34	1,721,276,038.37
2	Эргэлтийн бус хөрөнгө	7,035,735803.31	6,861,584,941.56	6,805,624,589.59	6,677,378,101.86
3	Нийт хөрөнгө	8,438,822,492.89	8,402,764,167.66	8,483,950,838.93	8,398,654,140.23
4	Нийт өр төлбөр	219,610,530.09	209,455,277.50	198,987,075.45	213,651,174.42
5	Эзэмшигчдийн өмч	8,219,211,962.80	8,193,308,890.16	8,284,963,763.48	8,185,002,965.81
6	Борлуулалтын орлого	1,494,879,283.52	1,367,696,294.36	1,334,591010.34	1,389,183,726.81
7	Нийт орлого	1,569,335,970.52	1,489,906,907.10	1,490,397,917.45	1,572,606,312.34
8	Нийт зардал	830,946,635.87	817,376,753.65	774,988,602.67	789,189,311.26
9	Нийт ашиг	820,420,575.30	750,829,448.23	794,898,101.23	870,464,204.26
10	Цэвэр ашиг	738,389,334.65	672,530,153.45	715,409,314.78	783,417,870.81
11	EPS /Нэгж хувьцаанд ногдох ашиг/	9.40	8.56	9.11	9.97
12	PE /Үнэ ашгийн харьцаа/	13.04	19.84	15.59	14.04
13	ROE /Хувьцаат капиталын өгөөж/	0.09	0.08	0.09	0.10
14	BV /Нэгж хувьцаанд ногдох дансны үнийн харьцаа/	1.23	1.70	1.42	1.40



Нийт орлого, нийт зарлага, цэвэр ашиг /сая.төг/



Нийт төлсөн татвар /сая.төг/



Хувьцааны ханшийн өөрчлөлт

Компанийн нэгж хувьцааны анхны ханш 2008 онд 100 ₮ байсан бол 2019 онд нэгж хувь
130 ₮ болсон бөгөөд дараах графикаар хувьцааны ханшийн өөрчлөлтийг харуулав.



2019 оны байдлаар нэгж хувьцаа зах зээл дээр дундажаар 130 төгрөгөөр арил
эзэмшигчдийн хөрөнгө 1.3 дахин өссөн байна.

Хувьцааны зах зээлийн үнэлгээ

"Гермес Центр" ХК нь Монголын хөрөнгийн бирж дээр 2 дугаар ангиллын компани
бөгөөд 2019 оны 12 дугаар сарын байдлаар зах зээлийн үнэлгээ 10.2 тэрбум төгрөг бол

Ногдол ашгийн өгөөж

"Гермес центр" ХК нь Монголын хөрөнгийн бирж дээрх хамгийн идэвхитэй ногдол аш
компаниудын нэгэн бөгөөд хувьцаа эзэмшигчдэдээ 2008 оноос эхлэн ногдол ашиг тар

2008-2019 онуудад тараасан ногдол ашгийг дараах графикаар харуулав.



...ох удирдлагын бүрэлдэхүүн

Үйцэтгэх захирал: Б.Оюунцэцэг
Нягтлан бодогч: О.Энхтуяа
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: Д.Эрдэнэсүрэн

...он удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

ТУЗ-ийн дарга: Д.Оюунсүрэн
ТУЗ-ийн ердийн гишүүд: Б.Оюунцэцэг
Д. Алтанчимэг
Ц.Түвшинжаргал
Н.Мөнхзул
Б.Амарсанаа
ТУЗ-ийн хараат бус гишүүд: Д.Туяа
Н.Батсайхан
Б.Алтангэрэл

ТҮРЭЭСИЙН ТАЛБАЙН ҮНЭ ТАРИФ /₮/

Талбайн нэр	Хэмжих нэгж	Огноо/Түрээсийн үнэ тариф				
		2016	2017	2018	2019	2020
...р давхрын павильон	м.кв	21 000	20 000	20 000	20 000	20 000
...давхрын павильон	м.кв	18 000	17 000	17 000	18 000	20 000
...р давхрын павильон	м.кв	18 000	17 000	17 000	18 000	20 000
...фис үзүүлэнгийн ...лбай	м.кв	18 000	17 000	17 000	18 000	20 000
...гуу	ш	150 000	150 000	150 000	150 000	200 000

...0 онд эхний 1, 2-р саруудад түрээсийн төлбөрт 10%-ийн хөнгөлөлт үзүүлнэ.

...компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ТУЗ-өөс сайшаан ...н.

...дарга Д.Оюунсүрэн: Манай компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь сүүлийн жилүүдэд ...тогтой бодлого баримталж ирснийг та бүхэн мэдэж байгаа. Цаашид ч мөн энэ бодлогоо ...ажиллана. Түрээсийн үнэ тарифыг өндөр хэмжээнд барьж, хэт их ашгийн төлөө явсан ...ямжилтыг үзүүлэхгүй байсан. Ийм учраас дараа дараагийн он жилүүдэд өндөр, огцом ...хүлээх хэрэггүй гэдгийг хувьцаа эзэмшигчдэдээ дахин хэлмээр байна. Дэлхийн ...болж орноож байгаа халдварт өвчний нөхцөл байдал ч биднийг өөрсдийн үйл ...даа халдварт өвчний эрсдлийг ч тооцох хэрэгтэй болж байгааг санууулж байна. Зөвхөн ...ажиллагаа, хүсэл зорилгоос үл шалтгаалах эдийн засгийн болон төрөл бүрийн эрсдэл

үүсэж байна. Манай компанийн гүйцэтгэх удирдлага нь 2019 оны үйл ажилла... санхүүгийн зорилтоо биелүүлэн ажилласныг ТУЗ-ийн ээлжит хурал дээр сайшаасан бө... байна уу.

Хувьцаа эзэмшигч С.Тамир : Хурлын даргатай санал нэг байна. Хурлын материал... компаниасаа имайлаар хүлээн авсан. Миний харилцагч "Би Ди Сек" ХХКомпан... хариуцлагатай ажилладаг тул компанийн хурлын талаарх тайлан, мэдээллийг бүрэн ... байсан тул саналын хуудсаа шууд бөглөөд явах саналтай байна. Энэ коронавирусын х... хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуулийн дагуу явуулж байгаа компанийнхаа ... талархаж байна. Та бүгд маань энэ хэцүү эгзэгтэй цаг мөчид эрүүл саруул байж, ко... үйл ажиллагааг тасралтгүй авч явж байгаад бид бүхэн баярлаж байна. Та нартаа ... хүсэн ерөөе. Хурлын дэгийн дагуу саналын хуудсыг бөглөж, саналаа өгөөд хурла... саналтай байна. Манай компанийн үйл ажиллагаа өнгөрсөн 2019 онд жигд явагд... цөмөөрөө сайшаан тэмдэглэх нь зүйтэй байна. 2020 оны санхүүгийн зорилтоо биелүүл... өрөөе. Гүйцэтгэх удирдлагын багтаа амжилт хүсье.

Хурлын дарга Д.Оюунсүрэн : За хувьцаа эзэмшигчдийн зүгээс өөр асуух асуулт байна у... бол дараагийн асуудлаа шууд хэлэлцүүлээд явах уу. Үнэхээр хүнд цаг үед ажилла... гүйцэтгэх удирдлагын баг болон компанийн ажиллагсдадаа талархаж байна. Хам... биднээс холуур байж, манай ажиллагсад эрүүл саруул байхад учиртай. Барилгын ... худалдааны төв учраас олон хүн холхиж, цугларч явдаг, өвчин тархах эрсдэл өндөр...

- *Хэлэлцсэн 1-р асуудлаар гаргасан шийдвэр : Компанийн 2019 оны үйл ажи... болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хуралд оролцсо... эзэмшигчид сайшаан тэмдэглэв.*

2. *Компанийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын байгууллагы... Хэлэлцүүлэгч Аудитын хорооны дарга: Д.Туяа*

Аудитын хорооны дарга Д.Туяа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Манай ... Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй "ЦЭСБ АУДИТ"ХХК-иар 4 дэх жилдээ ... аудит хийлгэж байна. Аудитын дүгнэлтийг та бүхэнд товч танилцуулья. "ЦЭСБ А... ХХКомпани нь "Гермес Центр" Хувьцаат компанийн 2019 оны 12-р сарын 31 ... дуусгавар болгосон санхүү байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гү... тайлан, нэмэлт тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэ... компанийн үзэж байгаагаар "Гермес Центр" ХК-ийн тухайн жилийн санхүүгийн тай... бүхий л үзүүлэлтүүд нь материаллаг асуудлаар Санхүүгийн тайлагналын Олон Улсын ... дагуу үнэн зөв толилуулагдсан байна" гэж дүгнэсэн байна. Хувьцаа эзэмшигч та бүхэ... хурлын материалд манай компанийн аудитлагдсан санхүү байдлын тайлан, орлогын ... тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан тус тус хавсарга... Аудитын хорооноос асууж тодруулах зүйл байвал асууна уу.

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Өөр асуух асуулт байхгүй бол дараагийн асуудалдаа ор...

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс энэ асуудлаар асууж тодруулах зүйлгүй, 100% санал ...

- *Хэлэлцсэн 2-р асуудлаар гаргасан шийдвэр : Компанийн 2019 оны санхүүгийн ... хийсэн аудитын байгууллагын дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа ... сайшааж, хурлын тэмдэглэлд оруулав.*

Компанийн 2018 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2019 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2020 оны ногдол ашгийн тухай. Хэлэлцүүлэгч ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн

дарга Д.Оюунсүрэн : Манай компани сүүлийн жилүүдэд хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хүндэтгэн ногдол ашгийг жилдээ 2 удаа олгосоор ирснийг хувьцаа эзэмшигч та бүхэн мэдэж байгаа. Ингээд хувьцаа эзэмшигч та бүхэндээ Компанийн тухай хуулийн дагуу 2018, 2019 оны ногдол ашгаа хэрхэн тараасан, мөн хэрхэн хуваарилсан, бас цаашид 2020 оны ногдол ашгаа хэрхэн хуваарилах талаарх мэдээллийг хүргэе.

центр" ХК нь 2018 оны эхний хагас жилд 461.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Компанийн ТУЗ-ийн 2018 оны 08-р сарын 31-ний өдрийн №02 тоот тогтоолын дагуу оны эхний хагас жилийн цэвэр ашгаас 392.7 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол хуваарилахаар шийдвэрлэсэн. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 5 төгрөг 2018 оны 09-р сарын 10-ны бүртгэлийн өдрөөр нийт 910 хувьцаа эзэмшигчид байсан тэдгээрт оногдох ногдол ашгаас:

- 10 хувьцаа эзэмшигчдийн 67 364 717 ширхэг хувьцааны ногдол ашиг 336.8 сая төгрөгийг компанийн төв байран дээр бэлэн мөнгөөр,
- 900 хувьцаа эзэмшигчдийн 11 178 284 ширхэг хувьцааны ногдол ашиг 55.9 сая төгрөгийг Үнэт Цаас Төвлөрсөн Хадгаламжийн Төвтэй гэрээ байгуулж тараасан болно.

Центр" ХКомпанийн 2018 оны сүүлийн хагас жилийн аудитаар баталгаажсан цэвэр ашгийн 330.7 сая төгрөг байлаа. Үүнээс: Компанийн ТУЗ-ийн 2019 оны 01-р сарын 25-ны өдрийн тоот тогтоолын дагуу 2018 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас 298.4 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаар хуваарилахаар шийдвэрлэсэн. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 5 төгрөг 80 мөнгө байсан. 2019 оны 02-р сарын 18-ны өдрийн бүртгэлийн өдрөөр нийт 911 эзэмшигчид байсан бөгөөд тэдгээрт оногдох ногдол ашгаас:

- 14 хувьцаа эзэмшигчдийн 67 507 749 ширхэг хувьцааны ногдол ашиг 256.5 сая төгрөгийг компанийн төв байран дээр бэлэн мөнгөөр,
- 897 хувьцаа эзэмшигчдийн 11 035 252 ширхэг хувьцааны ногдол ашиг 41.9 сая төгрөгийг Үнэт Цаас Төвлөрсөн Хадгаламжийн Төвтэй гэрээ байгуулж тараасан.

центр" ХК нь 2019 оны эхний хагас жилд 481.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Компанийн ТУЗ-ийн 2019 оны 08-р сарын 15-ны өдрийн №02 тоот тогтоолын дагуу 2019 оны хагас жилийн цэвэр ашгаас 447.7 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаар хуваарилахаар шийдвэрлэсэн. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 5 төгрөг 70 мөнгө 2019 оны 09-р сарын 02-ны бүртгэлийн өдрөөр нийт 937 хувьцаа эзэмшигчид байсан бөгөөд оногдох ногдол ашгаас:

- 11 хувьцаа эзэмшигчдийн 67 406 717 ширхэг хувьцааны ногдол ашиг 384.2 сая төгрөгийг компанийн төв байран дээр бэлэн мөнгөөр,
- 926 хувьцаа эзэмшигчдийн 11 136 284 ширхэг хувьцааны ногдол ашиг 63.5 сая төгрөгийг Үнэт Цаас Төвлөрсөн Хадгаламжийн Төвтэй гэрээ байгуулж тараасан болно.

2019 оны сүүлийн хагас жилийн аудитаар баталгаажсан цэвэр ашгийн хэмжээ 340.6 сая байсан. Компанийн ТУЗ-ийн 2020 оны 02-р сарын 05-ны өдрийн №02 тоот тогтоолын дагуу сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас 322.0 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол хуваарилахаар шийдвэрлэсэн. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 4 төгрөг 10 байсан. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн

одрийг 2020 оны 02-р сарын 28-ны өдрөөр тасалбар болгож, ногдол ашгийг 2020 оны 0[illegible] ны одроос эхлэн олгохоор шийдвэрлэсэн.

"Гермес центр" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь уламжлал ёсоор 2020 [illegible] хэмнигчдийнхээ эрх ашгийг дээдэлж, 2020 оны санхүүгийн тайланд 2 удаа аудит [illegible] гаргуулж, ногдол ашгийг оны хагас болон бүтэн жилээр хоёр удаа хуваарилах санал [illegible] хувьцаа эзэмшигчдэдээ мэдэгдэхэд таатай байна.

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Хэлэлцсэн асуудалтай холбоотой асуулт байна уу?

Хувьцаа эзэмшигч Д.Зоригт : СЗХороо ногдол ашгийг тараах ажиллагааг тогтоосон тухай [illegible] гаргасан гэж сонссон. Энэ тухай тайлбарыг сонсмоор байна.

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Манай компани нь бэлнээр буюу харилцах дансаараа авч [illegible] гаргасан хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийн мөнгийг компани дээр бэлнээр, хүсэлт [illegible] хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийн мөнгийг Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн [illegible] дамжуулан тараах ирсэн. Өөр онцлох зүйл юу байгаа билээ.

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: СЗХороо 2020 оны 1-р сарын 29-ний өдрийн 28 тоот [illegible] компанийн ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай тогтоолыг гарга[illegible] тогтоолоор нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь компаниас ногдол ашгийн мөнгө[illegible] урьдчилж бичгээр хүсэлт гарган, харилцах, хадгаламжийн дансандаа шилжүүлэн авах, мө[illegible] хувьцаа эзэмшигчдийн мөнгийг ҮЦТХТ-өөр дамжуулан гэрээ байгуулан тараах бол[illegible] утгатай байгаа. Энэ 2020 оны хувьд хувьцааны ногдол ашиг тараах шимтгэл хураамж, [illegible] хувь хэмжээ өөрчлөгдсөн. Зарчмын хувьд манай компани ногдол ашиг тараах асуудал [illegible] нэгэн маргаантай асуудал үүсгэдэггүй учраас энэ тогтоолыг цаашид биелүүлээд явах бо[illegible]

Хурлын дарга Д.Оюунсүрэн: Өөр асуулт байна уу? Байхгүй бол хурлын дэгийн дагуу [illegible] асуудлаа шуурхай хэлэлцэе. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс саяын хэлэлцсэн асуудлаа[illegible] байхгүй, хэлэлцсэн асуудлыг сайшаан тэмдэглэв.

- ***Хэлэлцсэн 3-р асуудлаар гаргасан шийдвэр : Компанийн 2018 оны ногдол [illegible] хуваарилж тараасан мэдээлэл, 2019 оны ногдол ашгийг хуваарилсан болон [illegible] ногдол ашгийг хуваарилах тухай мэдээллийг хурал оролцсон хувьцаа эзэмшигч[illegible] сайшаан дэмжив.***

4. ***Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, зардлын [illegible] тухай. Хэлэлцүүлэгч ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн***

Хурлын дарга Д.Оюунсүрэн : Та бүхэнд ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамш[illegible] зардлыг танилцуулж байна. Манай ТУЗ нь 9 гишүүнтэй. Улиралд 1 удаа буюу жилд [illegible] хуралддаг. "Гермес центр" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь өнгөрсөн жилд дөрөв [illegible] гаргаж зарцуулсан болно. Үүнд :

- Цалингийн зардал нийт 13.2 сая төгрөг
- ТУЗ-ийн гишүүн нь хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн 350 000.00 [illegible] цалин авдаг. Хуралд оролцоогүй тохиолдолд цалин олгодоггүй болно.

Компанийн гүйцэтгэх захирлын цалин урамшууллын зардалд нийт 58.3 сая төгрөг [illegible]

центр” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2020 онд дараах цалингийн санг өмнөх оны батлуулахаар Хувьцаа эзэмшигчдийн хуралд санал оруулж байна. Үүнд:

- ТУЗ-ийн дарга хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн 410 000 төгрөгийн цалин олгох – улиралд 1 удаа хуралдана
- ТУЗ-ийн гишүүн хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн 350 000 төгрөгийн цалин олгох – улиралд 1 удаа хуралдана
- Цалингийн нийт зардал 4 улирлаар тооцоход 14.2 сая төгрөг

ийн Гүйцэтгэх захирлын цалин урамшууллын зардал 73.2 сая төгрөг байна.

дарга Д.Оюунсүрэн: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин болон Гүйцэтгэх захирлын урамшуулалтай холбоотой асуух асуулт байна уу. Асуух асуулт байхгүй бол тогтоолын батлах уу?

эзэмшигчдийн зүгээс тогтоолын төслийг 100% дэмжиж батлав.

Хэлэлцсэн 4-р асуудлаар гаргасан шийдвэр : Компанийн ТУЗ-ийн зардлын төсвийн тогтоолын төслийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.

Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай. Хэлэлцүүлэгч ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн

дарга Д.Оюунсүрэн :“Гермес центр” ХК-ийн хувьцааны 5-аас дээш хувийг нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийг уламжлал ёсоор танилцуулдаг. Миний бие нь өөрийн гэр бүлийн хүн болох Д.Зоригтын хамт энэ компанийн 160 ширхэг хувьцаа буюу 83.9 хувийг хамтран эзэмшиж байна. Хурлын материалд танилцуулагдаж нийт хувьцаа эзэмшигчдэдээ хүргэсэн байгаа. Мөн хурлын материалаас дэлгэрэнгүй харилцаж болно.

эзэмшигчдийн зүгээс асуулт, санал байхгүй гэж хариулав.

дарга Д.Оюунсүрэн : Асуулт байхгүй бол дараагийн асуудалдаа орцгоое.

Хэлэлцсэн 5-р асуудлаар гаргасан шийдвэр : Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны мэдээллийг хурлын тэмдэглэлд оруулав.

Компанийн 2020 оны үйл ажиллагааны зорилт. Хэлэлцүүлэгч Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг

захирал Б.Оюунцэцэг : Хуралдаа оролцож санал бодлоо илэрхийлж байгаа та бүхэндээ баярлалаа. 2020 онд бидний төлөвлөгөө бүрэн биелэх боломжтой гэж бодож явлаа. Гэтэл гэнэт гарч ирсэн тахал шиг хурдан тархдаг аюулт халдварт өвчин бидний үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нь дамжиггүй боллоо. Энэ оны 3-р сард гэхэд манай худалдааны төв Улсын онцгой байдлын шийдвэрээр 3-р сарын 11-ний өдрөөс 3-р сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд 5 өдөр ажиллагаагүй түр хаасан билээ. Эдгээр 5 өдрийн түрээсийн төлбөрийг манай компани худалдагчдаасаа авахгүй бөгөөд нийтдээ 25 сая орчим төгрөгийн борлуулалтын орлогоо алдаж байгаа. Гэхдээ бид шантрахгүйгээр өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглаж “Ая худалдагч” барилгын материалын худалдааны төв байх уриагаа эрхэмлэн ажиллана.

Манай компани нь цаашдаа

- Нэгдүгээрт : Худалдан авагчдын эрх ашгийг дээдэлж, ая тухтай үйлчилж
- Хоёрдугаарт : Түрээслэгчдийн эрх ашгийг дээдэлж, тэднийг ажиллах нөхцлоор
- Гуравдугаарт : Ажиллагсдын эрх ашгийг хамгаалж, нийгмийн асуудлыг шийд
- Дөрөвдүгээрт : Хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцааны өгөөжийг нэмэгдүүлж

Компани нь 2020 оны эцэст 1 821.7 сая төгрөгийн цэвэр орлоготой, 788.9 сая төгрөгийн татварын дараах 890.1 сая төгрөгийн цэвэр ашигтай, нэгж хувьцаанд 11 төгрөг 33 монг ашиг оногдохоор төлөвлөсөн. Компани 16 ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулна төлөвлөгөөгөө ТУЗ-ийн ээлжит хурлаараа батлуулж, түүнийгээ хувьцаа эзэмшигч та танилцуулж байна. Дэлхий дахинд үүсээд байгаа нөхцөл байдалд нийцүүлэн Гермес материалын худалдааны төвөө ажиллуулж, та бүгдийн өмнө хүлээсэн үүргээ өөрсдөөс хэмжээнд биелүүлэх болно гэдгээ хэлье. Биднээс шалтгаалахгүйгээр төр захиргааны нийтийг хамарсан хөл хорио тогтоох, худалдааны төвийн үйл ажиллагааг түр асуудлууд гарч болзошгүй гэдгийг та бүхэндээ хэлж байна. Гэхдээ монголчууд бид урагш тэмүүлэх хүсэл байхад болно доо. Энэ аюулт өвчнийг дэлхий нийтээрээ ялан жил цөмөөрөө эрүүл саруул, энх тунх байж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг гэдэгт итгэл төгс байна.

Хурлын дарга Д.Оюунсүрэн : Компанийнхаа гүйцэтгэх удирдлагын баг хамт олондоо өвчний тархалтын эрсдэлтэй цаг үеийг даван туулж, 2020 оны төлөвлөсөн үүрэгт ажлуу биелүүлнэ гэдэгт итгэж байна. Орлого, зарлагын төсөв төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд манай компанийн ТУЗ шуурхай хуралдаж тухай бүр гаргаад явах болно. Сайн цаг айсуй гэдэгт бүрэн итгэж байна. За өөр асуулт байна уу.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт байхгүй гэж хариулав.

- ***Хэлэлцсэн 6-р асуудлаар гаргасан шийдвэр : Компанийн 2020 оны үйл ажи зорилтыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% сайшаан дэмжлээ.***

"Гермес центр"ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нийт 1 цаг 10 мин үр 10 минутанд дуусав. Хурал амжилттай болж өнгөрлөө.

УЛААНБААТАР ХОТ
ГЕРМЕСЦЕНТР ХК
ТТБ1437 ☎ 2773678

Хурлын тэмдэглэлтэй

.....ТУЗ-ийн дарга Д.Оюу

Хурлын тэмдэглэлийг

.....ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Эрдэ